



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/165

Чингис хот

Г Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ийн "а", Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1, 5 дугаар зүйлийн 5.1, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт байгаа мал амьтныг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, угаалга, туулгалт, боловсруулалт, лабораторийн шинжилгээнд хамруулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зэрэг төлөвлөгөөт ажлыг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай зохион байгуулж малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж, хүн хүч, тээврийн хэрэгслээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бий болгосон малчин, мал бүхий иргэн, холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т хариуцуулсугай.

3. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах, мал амьтны хашаа байр, бэлчээр болон мал аж ахуйн гаралтай түүхий эд хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг газруудыг халдваргүйтгэх ажлыг мал эмнэлгийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Аймгийн нутаг дэвсгэрт мал амьтныг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тандан шинжлэх, оношлох, халдваргүйтгэх арга хэмжээнд шаардагдах эм урвалж, биобэлдмэл, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/-т үүрэг болгосугай.

5. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх оношлогоо, шинжилгээ, халдваргүйжүүлэлтийн явц гүйцэтгэлд хяналт, шалгалт хийхэд шаардагдах зардлыг аймгийн төсөвт батлагдсан мал эмнэлгийн тарилгын үйлчилгээний хөлсний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ /-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА